

## 6.7.2 Төслийн хэрэгжилт

### а. Хог ачиж цуглуулах тогтолцоог сайжруулах

Хог хаях журмыг эхний ээлжинд 3-р хорооны хойд хэсэг, 1-р хорооны зүүн хэсэгт нэвтрүүлж эхэлсэн ба зорилтод бүс нутагт цааш нь шат шатаар өргөжүүлсэн.

Бүс нутаг бүрт хог хаях журам нэвтрүүлж эхэлсэн өдрийг доорх хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 6-76: Хог хаях журмын өргөжүүлэх ажил

	Бүс нутаг	Эхлүүлсэн өдөр
1-р бүс	3-р хорооны хойд хэсэг 1-р хорооны зүүн хэсэг 4-р хорооны 13-р байр	8-р сарын 28
2-р бүс	3-р хорооны өмнөд хэсэг	9-р сарын 11
3-р бүс	1-р хорооны үндсэн хэсэг (1-р хороонд дахин туршилтыг эхлүүлсэн)	9-р сарын 18 (10-р сарын 23)
4-р бүс	2-р хорооны оршин суугчдын хэсэг	10-сарын 16
5-р бүс	4-р хороо	11-р сарын 14

Хог хаях журам нэвтрүүлэх ажлын явцыг доор дурьдав.

### а.1 Суурь судалгаа

Дараах судалгаануудыг 2006 оны 6 ба 7-р сард авсан. Тэдгээр судалгаануудын нарийвчилсан үр дүнг мэдээлэл, материалын түүвэрт үзүүлсэн байгаа.

- Оршин суугчдаас авсан ярилцлага судалгаа (Хороо бүрээс 5 хүн)
- СӨХ-өөс авсан ярилцлага судалгаа (44 СӨХ)
- Ресторан, бар, кафе зэрэгээс авсан авах ярилцлага судалгаа

### а.2 Бэлтгэл ажил

Бүс нутаг болгонд хог хаях журам нэвтрүүлж эхлэхийн өмнө сурталчилгааны материал бэлтгэх, янз бүрийн уулзалт, хурал зэрэгт судалгааны баг нэг долоо хоног зарцуулж байсан.

#### (1) Хорооны Засаг дарга болон СӨХ-үүдтэй уулзах

Бүс нутаг бүрт төлөвлөгөө гаргаж дуусгахын өмнө хорооны Засаг дарга болон СӨХ-тэй уулзалт зохион байгуулж байсан бөгөөд хэрэв тэд хог хаях журам, төслийн төлөвлөгөө, ялангуяа хог хаях журмын агуулагийг зөвшөөрч байвал ажлын төлөвлөгөөг хэлэлцэн эцэслэн шийдвэрлэсэн.

Эхэндээ ихэнх СӨХ-үүд хог ачих давтамжыг өдөрт хоёр удаа байснаа долоо хоногт 3 удаа болгож бууруулсан учир хог хаях журам хэрэгжиж чадах эсэхэд эргэлзэж байсан. Судалгааны баг ТҮК болон оршин суугчдын хооронд тодорхой журам байхгүй байгаа учир гол хүндрэл үүсч байгаа болон энэ нь хог ачиж цуглуулах үйлчилгээний зардлын хувьд маш чухал болохыг онцлон тайлбарлаж байсан.

2, 3 болон 4-р хорооны Засаг дарга нар санал болгосон хог хаях журмыг зөвшөөрч, санал нэгдэн бүрэн чадлаараа туслах болон СӨХ-үүдийг төсөлтэй хамтран ажиллахад нь үүрэг өгөх болно гэдгээ амласан. Үүний үр дүнд тэдгээр хороодын дийлэнх СӨХ хог хаях журам нэвтрүүлэх, хог ачиж цуглуулах тогтолцоог сайжруулах төсөл болон хог хаях журмыг айл өрхүүдэд танилцуулж тараахтай санал нэгдсэн.

1-р хорооны гол үндсэн хэсгийн олонх СӨХ-үүд анхны уулзалтаар санал болгосон хог хаях журмыг зөвшөөрөөгүй бөгөөд хорооны Засаг дарга нь тэдгээр СӨХ-үүдийн шийдвэрийг хүлээж авсан. Үүний улмаас судалгааны баг болон Хотын захиргаа 1-р хороонд хог хаях журам бүрэн хэмжээгээр хэрэгжээгүй гэж үзсэн.

## **(2) Хог хаях журам бий болгох**

Суурь судалгааны үр дүн дээр үндэслэн доорх журмыг СӨХ болон хорооны Засаг дарга нарт санал болгож хэлэлцсэний дараа эцэслэн шийдвэрлэсэн.

Хог хаях журам 1: Хог хаях өдөр болон цагийн тухай

- Зөвхөн хог ачих хуваарьт өдөр л хогоо хаяж болно. (долоо хоногт 3 удаа)  
А бүс: (Хороо 2 & 3): Даваа, Лхагва, Баасан  
В бүс: (Хороо 1 & 4): Мягмар, Пүрэв, Бямба
- Өглөөний 9:00 цагт хогоо гаргаж хаяна.

Хог хаях журам 2: Хог түр тавих газрын тухай.

- Хогоо зөвхөн тусгайлан заасан газарт тавих ёстой. Хогны машинд шууд хогоо аваачиж өгч болно.

Орон сууцны байрны бүтцээс хамаарч хог түр тавьж болох газрыг СӨХ шийдэж тогтоосон. Хуучны намхан байрнуудын ихэнх нь хог түр хадгалах газар байхгүй байсан бөгөөд хангалттай зайтай биш байсан ч орцны хажуугын зайг хог түр тавих газраар сонгосон.

Хог хаях журам 3: Хог хаях арга хэлбэрийн талаар  
Дараах хэлбэрээр хогоо хаях ёстой.

- Хогоо гялгар уут юмуу хайрцагт хийж хаяна.  
Гялгар уутныхаа амыг сайтар боох хэрэгтэй
- Хогоо шууд ил задгай газар бүү хая.

Хог хаях журам 4: Олон нийтийн эзэмшлийн газарт хог хаяхыг хориглох

- Гудамж талбай болон цэцэрлэгт хүрээлэн зэрэг олон нийтийн эзэмшлийн газарт хог хаях хориотой.

## **(3) Сурталчилгааны материал бэлтгэх**

Доорх сурталчилгааны материалуудыг бэлтгэсэн.

### **Орон сууцны орцны үүдэнд наах мэдээллийн самбар**

Хог ачих хуваарьт өдөр болон хог хаях журмын талаарх мэдээллийг агуулсан мэдээллийн самбарыг орцны үүдэнд наасан. Судалгааны багийн зүгээс СӨХ-үүдэд ухуулах хуудас, мэдээллийн самбар байрлуулах самбар хийж тавихад нь дэмжлэг үзүүлсэн.



Зураг 6-55: Орон сууцны орцны үүдэнд наасан самбар

### Ухуулах хуудас

Хэд хэдэн ухуулах хуудас бэлтгэсэн.

- Аж ахуйн нэгж болон айл өрхүүдэд тараах ухуулах хуудас
- Хог хаях журмыг ерөнхийд нь тайлбарласан хуудас.
- Онцлон тайлбарласан хуудас: Зарим байрны ихэнх оршин суугчид нэг давхартаа хогоо авчирч тавихгүй, орцон дотроо давхартаа тавьдаг, эсвэл хуучин хогийн ил задгай цэг дээр хогоо хаясаар байсан. Үүнийг зогсоохын тулд илүү тодорхой заавар өгөхөөр дахин ухуулах материал бэлтгэж оршин суугчдад тараасан.
- Анхааруулах материал (3-р хороонд Засаг дарга нь хорооны оффисын ойролцоох хууль бусаар хог ил задгай хаядаг байсан цэг дээр хог хаясаар байсан зарим хүмүүст анхааруулга өгөх үүднээс хоёр дахь идэвхит ажиллагааг зохион байгуулсан. Тэрхүү идэвхит ажиллагааны анхааруулах материал нь

Мэдэгдэх хуудас

Танилцуулах материал

Зураг 6-56: Ухуулах хуудас

### Гудамжинд суурилуулсан самбар

Хорооны Засаг дарга болон зарим СӨХ-үүдийн хүсэлтэд үндэслэн хог ил задгай хаядаг байсан хуучин цэг дээр хог хаясаар байсан хүмүүст анхааруулга өгөх үүднээс хогийн ил задгай хуучин цэг дээр гудамжны самбар суулгасан. Тухайн самбар дээр хууль бусаар хог хаясан иргэдийг ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлын хуулиар хог хаях журмын дагуу торгох талаар анхааруулсан.



Зураг 6-57: Гудамжны самбар

#### (4) Үйлчлэгч, жижүүрүүдтэй уулзах

Үйлчлэгч, жижүүрүүдийг бүрэн ойлгуулах үүднээс СӨХ хог хаях журмыг зөвшөөрсний дараа СӨХ бүрийн үйлчлэгч, жижүүрүүдтэй уулзалт зохион байгуулсан. Зарим тохиолдолд хэд хэдэн СӨХ-үүдийн үйлчлэгч, жижүүртэй хамтад нь уулзсан. Зарим үйлчлэгч, жижүүрүүд хэрэв олон оршин суугчид хог ачих хуваарьт бус өдөр орцонд хогоо хаявал асуудал үүсэх учир орцны хажуугын зайд хогоо тавих төлөвлөгөөг эсэргүүцэж байсан. Судалгааны багийн зүгээс хог хаях журмын мэдээллийг тараах нь маш чухал гэдгийг онцлон тайлбарлаж, ихэнх оршин суугчид сайтар ойлготол нэмэлт сурталчилгааны материал бэлтгэж тараах болно гэдгээ амалсны эцэст ихэнх үйлчлэгч, жижүүрүүд хог хаях журмыг зөвшөөрсөн.

#### (5) Оршин суугчдын хурал

Хог хаях журам нэвтрүүлэхийн өмнө хорооны Засаг дарга болон СӨХ-тэй хамтарч оршин суугчдын хурал зохион байгуулсан.





### **(б) Ярилцлага судалгаа**

Төслийн явцын талаар мэдэхийн тулд хог хаях журам нэвтрүүлсний нэг-хоёр сарын дараа айл өрх, үйлчлэгч болон СӨХ-өөс ярилцлага судалгаа авсан.

#### **б. Ангиан цуглуулах тогтолцоог нэвтрүүлэх**

Ангиан цуглуулах тогтолцоог 2006 оны 11-р сарын 18-ны өдрөөс эхлэн нэвтрүүлж эхэлсэн бөгөөд нэг сарын хугацаанд үргэлжилсэн.

### **6.7.3 Үр дүн ба Үнэлгээ**

#### **а. Үр дүн**

##### **а.1 Хог ачиж цуглуулах тогтолцоог сайжруулах**


#### **Одоогийн нөхцөл байдал**

Хог ачиж цуглуулах тогтолцоог сайжруулах төслийн үнэлгээний нэг гол хүчин зүйл нь хог хаях хууль бус хогийн ил задгай цэгийн тоо юм. Мөн ярилцлага судалгааны үр дүнд үндэслэн хүмүүсийн ухамсар болон хэвшил хэрхэн өөрчлөгдсөнийг үнэлнэ. Хог ачих ажилд зарцуулагдах хугацаагаар хог ачиж цуглуулах ажлын үр ашгийг өөрчлөгдсөн эсэхийг үнэлнэ.

#### **(1) Нэг дэх бүс нутаг**

3-р хорооны хойд хэсгийн гурван СӨХ хамрагдсан.

Ирээдүй-3: энэ бүс нутгийн хамгийн сайн СӨХ-үүдийн нэг бөгөөд удирдах үүргээ сайн гүйцэтгэж, мэдээллийг идэвхтэй тарааж, оршин суугчид болон гадны явуулын хүмүүсийн аль алиных нь хог хаяж байгаа арга хэлбэрийг сайн хянаж ажилласан. Үүний үр дүнд орцноос орцон дахь хог ачиж цуглуулах тогтолцоо саадгүй хэрэгжсэн бөгөөд ил задгай хогийн хоёр цэгээ хурдан устгаж чадсан. Энэ нь энэхүү СӨХ-д хог ачих ажлын цагийг богиносгосон ач холбогдолтой гэж үзсэн.



Туршилтын төслийн өмнөх хогийн ил задгай цэг



Туршилтын төслийн дараа



Хог ачих өдрийн өглөө



Туршилтын төслийн дараах хог ачих ажил

Гэсэн хэдий ч зарим нэгэн оршин суугчид буруу цагт хогоо хаясаар байгаа бөгөөд байрны үйлчлэгч тухайн хогийг байрны подвалд хадгалж байгаад хогны машин аж ахуй нэгжийн хогийг ачихаар үдээс хойш ирэхэд нь тэдгээр хогоо ачуулдаг байна.

Нөгөө хоёр СӨХ-ийн хувьд эхэн үед хог ачих шинэ тогтолцоо сайн хэрэгжихгүй байсан. Нэг СӨХ нь шинээр байгуулагдсан бөгөөд орон сууцыг нь барисан барилгын компани СӨХ-ийн үүргийг гүйцэтгэж байсан. Тухайн СӨХ-ийн менежментийн хэлбэр нь бизнесийн чиглэлтэй бөгөөд олон нийтийн үйл ажиллагаа байхгүй байсан нь судалгааны багийнханд айл өрхүүдэд хүрч ажиллахад хүндрэлтэй байсан бөгөөд хог хаях журмыг ихэнх оршин суугчдад ойлгуулж мэдүүлэхэд цаг их зарцуулсан.

Судалгааны багийнхан эхлээд СӨХ-ийн жижүүрийг хажуугын цэцэрлэг дэх хог хаях ил залгай хуучин цэг дээр хяналт хийлгэсэн боловч жижүүр ажиллаагүй. 3-р хорооны Засаг дарга тэднийг хог хаягч этгээдийг торгох эрхтэй хэсгийн дарга нараар сольж ажиллуулсан. Нэмэлт ухуулах материал үргэлжлүүлэн тараах болон идэвхтэй хяналтын ажил хийсний үр дүнд хог ил задгай хаядаг оршин суугчдыг тоо аажмаар багассан.



Туршилтын төслийн өмнөх цэцэрлэгийн урд талын хогийн ил задгай цэг



Туршилтын төслийн дараа

Гурав дахь СӨХ нь олон байруудтай том СӨХ бөгөөд нийгмийн олон янзын асуудлуудтай байсан. Ихэнх оршин суугчид нь тэтгэвэрт гарсан бөгөөд орлогын түвшин харьцангуй бага байсан. Зарим оршин суугчид нь архинд донтсон байсан. Ихэнх оршин суугчид нь эхэн үедээ хог хаях журмыг үл тоомсорлож байсан ба хогийн ил задгай цэгийн хэмжээ багассан хэдий ч бүр мөсөн устаж алга болохгүй байсан.

3-р хорооны Засаг дарга хог хаях журам нэвтрүүлж эхэлсний дараа эхний амралтын өдрүүдэд хогийн ил задгай хуучин 3 цэг дээр компани ажил явуулсан. Үүний үр дүнд оршин суугчид хог хаях журмыг дагах болсон.

Одоо тэдгээр гурван СӨХ-ийн хогийг ачих нийт хугацаа үр ашигтайгаар багассан.



Туршилтын төслийн өмнөх хогийн ил задгай  
цэг



Туршилтын төслийн дараа



Хог ачих өдөр

4-р хорооны нэг байр төсөл хэрэгжүүлсэн эхний бүс нутагт хамрагдсан. Тухайн байрны хажууд хогийн ил задгай том цэг үргэлж байдаг байсан. Тухайн байрны нэг давхрын ресторан, албан байгуулагууд болон оршин суугчид нь гол хууль бусаар хог хаягчид байсан. ТҮК ресторан, албан байгууллагуудын хууль бусаар хог хаях явдлыг зогсоох үүрэгтэй байсан бол тухайн байрны СӨХ-ийн дарга оршин суугчдыг хог хаях журам мөрдүүлэх явдлыг хариуцсан. ТҮК ресторануудыг дахин дахин шалгасны үр дүнд ресторанууд хогоо хууль бусаар хаядаг байдлаа зогсоосон.



Туршилтын төслийн өмнөх хогийн ил задгай  
цэг



Туршилтын төслийн дараа

## (2) Хоёр дахь бүс нутаг

3-р хорооны өмнөх хэсгийн гурван СӨХ хамрагдсан. Тэдгээрийн нэг СӨХ нь дотоод ноцтой асуудалтай байсан. СӨХ-н даргагүй байсны дээр СӨХ нь бүрэн хэмжээгээр ажилладаггүй байсан. Энэ нь судалгааны багийнханд оршин суугчдад хүрч ажиллахад бараг боломжгүй байсан. Олон оршин суугчид байрныхаа орцон дотор болон хогийн ил задгай хуучин цэг дээр хогоо хаяж байсан. Харин нөгөө нэг СӨХ-ийн дарга хог хаях

журмыг хүчтэй эсэргүүцэж байсан. Үүний улмаас олонх оршин суугчид 3-р хорооны даргын идэвхтэй ажиллагааг хамаарахгүйгээр барилгын ажлын урд талын хогийн ил задгай цэг дээр хог хаях хуваарьт бус өдөр хогоо хаясаар байсан.

Мөн түүнчлэн төв гудамжны дагуух олон аж ахуй нэгжүүд хогийн ид задгай цэг дээр хогоо хаясаар байсан. ТҮК тэдгээр бүх аж ахуй нэгжээр орж уулзан хогоо ил задгай хаях байдлаа зогсоож, хогны машин иртэл хогоо хадгалж байхыг хүссэн.

Хорооны Засаг дарга оршин суугчдыг хог хаях журмын ач холбогдлыг ойлгуулах болон торгох арга хэмжээний талаар анхааруулахын тулд компани ажлыг 10-р сарын 20-ноос эхлэн зохион байгуулсан. Компани ажлын дараа хогийн ил задгай цэг багассаар эцэстээ алга болсон.



Туршилтын төслийн өмнөх хогийн ил задгай цэг



Туршилтын төслийн дараа



Туршилтын төслийн дараах хог ачих ажил



Хэдий тийм боловч зарим оршин суугчид хог ачих хуваарьт бус өдөр орцондоо хогоо тавьж байгаа бөгөөд энэ нь оршин суугчдад асуудал болж байна.

### (3) Гурав дахь бүс нутаг

1-р хорооны ихэнх СӨХ-үүд санал болгож буй хог хаях журмын эсрэг саналаа илэрхийлж байсан бөгөөд хорооны Засаг дарга нь СӨХ-үүдийн уулзалт дээр тэднийг төсөлд хамтран ажиллахыг ятгаж ухуулаагүй. Хотын захиргаа болон судалгааны багийнхан хог хаях журмыг 1-р хорооны нийт бүс нутгаар хэрэгжүүлэхгүй гэж шийдвэрлэсэн. Харин хогны машин хамгийн түрүүнд хог ачихаар ирдэг бүс нутгийн СӨХ хог хаях журам нэвтрүүлэхийг зөвшөөрсөн бөгөөд судалгааны багийнхан тухайн СӨХ-д эхний ээлжинд хог хаях журам нэвтрүүлэхээр шийдвэрлэсэн.

1-р хорооны Засаг даргын сонгосон хяналт хийх хүн хууль бусаар хог ил задгай хаях цэг дээр хяналт хийгээгүй болон СӨХ-ийн оролцоо хязгаарагдмал байсны улмаас ихэнх оршин суугчид хог хаях арга хэлбэрээ өөрчлөөгүй. Мөн түүнчлэн амлаж байсны дагуу хогны хуучин машиныг шинээр солиогүй болон тухайн хуучин машин ихэнхдээ



механикийн асуудлын улмаас хоцорч ирж байсан. Энэ нь оршин суугчид журмыг дагах байдлыг үгүй болгосон. Үүний үр дүнд хог ачиж цуглуулах шинэ тогтолцоо хэрэгжээгүй бөгөөд хог ил задгай хаядаг хоёр цэг өмнөхтэйгээ адилаар байсаар л байна.




Туршилтын төслийн дараах 1-р хороон дээрх хог ил задгай хог хаях цэг

#### (4) Дөрөв дэхь бүс нутаг

3-р хорооны амжилттай үр дүнг хажуугынх нь бүс нутаг аажмаар мэдсэн байна. 2-р хорооны бүс нутагт орон сууцны байрны дунд хогийн ил задгай том цэг байдаг байсан бөгөөд оршин суугчид болон хорооны Засаг дарга, СӨХ-үүд нь 2-р хороонд хог ачиж цуглуулах тогтолцоог сайжруулах төслийг баяртай хүлээн авсан.

Мөн түүнчлэн 2-р хорооны Засаг дарга өөрийн ажилчид болох хорооны байцаагч, СӨХ-ийн жижүүрийг долоо хоногийн турш хяналт хийх хүнээр томилсон. 2-р хороонд хяналт хийсэн бүх гурван хүн маш сайн ажилласан. Үүний үр дүнд тэрхүү хэсэгт олон аж ахуй нэгжүүд байсан ч хог хаях журам саадгүй хэрэгжсэн. Хогны машин 2-р хорооны хогийг ачихаас өмнө 3-р хорооны урд хэсгийн хогийг ачдаг бөгөөд төсөл хэрэгжсэний дараа ихэнхдээ үдээс өмнө хог ачих ажлаа дуусгадаг болсон.



Туршилтын төслийн өмнөх хогийн ил задгай цэг

Туршилтын төслийн дараа



Туршилтын төслийн дараах хог ачих ажил

### (5) Тав дахь бүс нутаг

Бэлтгэл ажлын түвшин өөр өөр үр дүнтэй байсан.

Солонго-3 СӨХ болон 21-р байрны оршин суугчид 21-р байрны урд талын хогийн ил задгай том цэгийн асуудалд санаа их зовж байсан ба “Солонго -3” СӨХ болон 21-р байрны жижүүр бэлтгэл ажилд идэвхтэй оролцсон. Хэдийгээр 21-р байрны оршин суугчид СӨХ-гүй боловч жижүүр нь маш сайн ажиллаж, мэдээллийг оршин суугчдадаа сайн тарааж орчноо цэвэр болгож чадсан. Эцэст нь оршин суугчид хог хаях журмыг сайтар ойлгож, хог ачиж цуглуулах шинэ тогтолцоо саадгүй хэрэгжиж, хогийн ил задгай том цэг устсан.



Туршилтын төслийн өмнөх хог ачих ажлын байдал



Туршилтын төслийн дараах хог ачих ажлын байдал

4-р хорооны оффисын хажуугын СӨХ-н дарга бэлтгэл ажлын үеэр удаан хугацаагаар байхгүй байсан бөгөөд бэлтгэл ажил хийгдээгүй. Тухайн СӨХ-ийн олонх оршин суугчид буруу өдөр орцондоо хог хаяж байна. Хэдийгээр хорооны урд талын ил задгай хогийн том цэг устаж алга болсон ч хажуу талын 41-р байрны хажууд шинээр хогийн ил задгай цэг үүсч байна.



Туршилтын төслийн өмнөх хогийн ил задгай цэг



Туршилтын төслийн дараах хогийн ил задгай цэг



Туршилтын төслийн дараах шинээр үүссэн хогийн ил задгай цэг

### **Ярилцлага судалгааны үр дүн**

Ярилцлага судалгаанд олж тогтоосон гол үр дүнг доор нэгтгэвэл:

- Ярилцлага судалгаа хийх үед айл өрхүүдийн 15% нь хог хаях журмыг мэдэхгүй байсан.
- Хог хаях журмын талаар мэдэж байгаа оршин суугчдын 90% нь хог хаях хуваарьт өдрийн талаар мэдэж байсан. (долоо хоногт 3 удаа)
- Айл өрхийн 82,2% нь журмыг дагаж мөрддөг.
- Хог хаях журмыг үргэлж болон ихэнхдээ мөрддөг тэдгээр оршин суугчдын 78.4% нь давтамж нь болж байна гэж хариулжээ.
- Хог хаях журмыг үргэлж болон ихэнхдээ мөрддөг тэдгээр оршин суугчдын 60% нь хогоо тусгайлан заасан газраа тавьдаг бол 40% нь хогны машинд шууд хогоо өгдөг гэжээ.
- Айл өрхүүдийн 87.7 % нь, харин СӨХ-үүдийн 88.5% (23) нь хог ачиж цуглуулах шинэ тогтолцоо нь өмнөх тогтолцооноосоо дээрдсэн гэж хариулсан бол 3 СӨХ өмнөх тогтолцоо нь илүү дээр байсан гэж үзсэн байна.
- Айл өрхүүдийн 46.6 % нь ухуулах хуудсыг уншаагүй гэж хариулсан байна.
- Айл өрхүүдийн 75% нь тэдний орчны нөхцөл байдал сайжирсан гэж хариулсан бол 60% нь тэдний хатуу хог хаягдлын менежментийн талаарх ухамсар, мэдлэг нь дээшилсэн гэж үзжээ.
- Хэдийгээр 15 СӨХ зарим нэг өөрчлөлтийг санал болгосон ч бүх СӨХ-үүд хог ачиж цуглуулах шинэ тогтолцоог дагаж дэмжнэ гэдгээ илэрхийлсэн байна.

#### **а.2 Ангилан цуглуулах тогтолцоог нэвтрүүлэх**

Оршин суугчид ангилан ялгах тогтолцоонд сайн оролцож байсан боловч оршин суугчдын ялгаж хаясан хогноос архи болон пивоны шилэн лонх, хуванцар сав, хөнгөн цагаан лааз зэргийг байрны үйлчлэгч ялгаж аваад хоёрдогч түүхий эдийн ченжүүдэд зардаг. Тэд үүгээрээ долоо хоног бүр 500-1000 төгрөг олдог байна. Үүний үр дүнд ачигдах дахин ашиглагддаг хог хаягдлын хэмжээ хязгаарлагдмал болсон.



Ялгаж хаясан дахин ашиглагдах хог хаягдал



Үйлчлэгчийн ялгаж авсан хаягдал



Ангилан цуглуулах тогтолцоонд ялгаж хаясан дахин ашиглагддаг хаягдлын нийт хэмжээ

## в. Үнэлгээ

### в.1 Хог ачиж цуглуулах тогтолцоог сайжруулах

#### **Орцноос хог ачих тогтолцоо сайн ажиллаж байна.**

Ерөнхийдөө төслийн үр дүн төлөвлөгөөт бүсэд орцноос хог ачиж цуглуулах тогтолцоо боломжтой гэдгийг харуулж байна. Орон сууцны намхан байрнуудын хувьд орцны хязгаарлагдсан зай нь хүндрэл үүсгэж байна. Ялангуяа цөөн тооны оршин суугчид буруу өдөр хогоо хаяж байгаа нь шинэ тогтолцоонд хүндрэл учруулж байна. Зарим тохиолдолд орон сууцны байрны хажууд хог ил задгай хаядаг шинэ цэг үүссэн.

#### **Тодорхой нөхцөлд хог хаях журам хэрэгжиж байна.**

Хог ачиж цуглуулах үйлчилгээний давтамж багассан хэдий ч оршин суугчдын ихэнх нь хог хаях журмыг мөрдөж байна. Доорх нөхцөлд санал болгож буй нөхцөлд хог хаях журам хэрэгжиж байна.

- Хангалттай бэлтгэл ажил

Бэлтгэл ажил хангалттай хийгээгүй тохиолдолд олон оршин суугчид хогоо буруу цагт хаясаар байсан бөгөөд энэ нь замбараагүй байдал үүсгэж байсан.

- Шинэ тогтолцоог эхлүүлсний дараах хэсэг хугацаанд хатуу хяналтын ажил хийх.

Хяналт хийх тохиромжтой хүн сонгоогүй тохиолдолд олон тооны оршин суугчид хог ил задгай хаядаг байсан хуучин цэг дээр хогоо хаясаар байсан.

- Хорооны Засаг дарга болон СӨХ тасралтгүй сурталчилгаа хийх

Хэдий сайн зохион байгуулалттай СӨХ байсан ч цөөн тооны оршин суугчид хог хаях журмыг үл ойшоож, мэдэхгүй байсан зэрэг асуудалтай тулгарч байсан. Хорооны Засаг дарга болон СӨХ-ийн тасралтгүй ухуулан сурталчлах идэвхтэй оролцоо нь хогийн ил задгай хуучин цэг дээр хогоо хаясаар байсан иргэдийн тоог багасгасан.

#### **Хог ачиж цуглуулах ажлын үр ашиг**

Хогийн ил задгай цэг устаж алга болох нь хог ачих ажлын хугацааг багасгах ач холбогдолтой. Гэсэн хэдий ч рейсийн тоо өдөрт зөвхөн нэг удаа хийдэг нь өөрчлөгдөөгүй. Хог ачих ажлын жинхэнэ үр ашгийг нэмэгдүүлэхийн тулд ТҮК бүх газар нутагтаа хог ачих хуваариа өөрчлөх шаардлагатай.

#### **Төслөөр олж авсан ашиг тус**

Шууд нөлөө	Хоёрдогч нөлөө
1. Хог тархаж хөглөрөх үзэгдэл алга болсон	Оршин суугчид болон жуулчдыг татах
2. Гудамж шүүрдэх ажил багассан	Өртөг багасах
3. Хот цэвэр болж байна	Жуулчдыг татах
4. Эзэнгүй нохдын тоо багассан.	Өртөг багасах
5. Хотын хог түүгчийн тоо багассан.	Оршин суугчид болон жуулчдыг татах
6. Хог ачих ажил хурдан бөгөөд хялбар болсон	Хог ачих ажлын өртөг багасах
7. Хогоо гэрээгүй хаядаг байсан аж ахуй нэгжийг олж тогтооно.	Аж ахуй нэгжийн хаягдлаас олох орлого ихсэх
8. Хүмүүс хогоо хамаагүй хаяхаас тэнгэлзэх	Хүмүүсийн хандлагыг өөрчлөхөд туслах

#### **6.2 Ангиан цуглуулах тогтолцоог нэвтрүүлэх**

Төслийн хэрэгжилтыг доор дурьдвал:

- Ихэнх сайн зарагддаг архи, пивоны шилэн лонх, хуванцар сав болон хөнгөн цагаан лаазыг хог ачигч нарыг ачихаас өмнө байрны үйлчлэгч ялгаж авдаг.
- Эх үүсвэр дээр нь дахин ашиглагддаг хог хаягдлыг ялгавал энэ тогтолцоо нь үр ашигтай байж чадна.
- Тэдгээр ашигтай дахин ашиглагддаг хаягдал нь дахин ашиглагддаг хог ачиж цуглуулах ажлаар хоёрдогч түүхий эдийн үйлдвэр лүү зөөгдөхгүй. Иймд хоёрдогч түүхий эдийн үйлдвэр дахин ашиглагддаг хаягдал цуглуулах ажлаас тэдгээр ашигтай түүхий эдүүд ирнэ гэж хүлээхгүй.
- Дахин ашиглагддаг хаягдал цуглуулах ажлаар цугларсан хаягдал нь RDF-н түүхий эд болоход маш тохиромжтой.

#### **6.7.4 Сургамж ба Зөвлөгөө**

##### **а. Хог ачиж цуглуулах тогтолцоог сайжруулах**

##### **а.1 Сургамж**

Туршилтын төслөөс өмнө Чингэлтэй дүүргийн ТҮК хогийн ил задгай цэгээс сэргийлэхийн тулд хог ачих үйлчилгээний давтамжаа өдөрт хоёр удаа болгож ихэсгэсэн байсан. Хэдийгээр өдөрт хоёр удаа ачдаг байсан ч дүүргийн төв хэсгийг хангалттай цэвэр байлгаж чадахгүй байсан. Нөгөөтэйгүүр Хотын захиргаа тийм өндөр давтамжтай хог ачих үйлчилгээгээр хангаж чадахгүй. Иймд Хотын захиргаа болон ТҮК өөр арга хэмжээ авах шаардлагатай байсан.

Туршилтын төслийн үр дүн нь хог хаях журмын хамт орцноос хог ачих тогтолцоо нь хог ачих үйлчилгээний давтамжийг багасгасан ч хогийн ил задгай цэг үүсэхээс сэргийлэх болон хог ачих ажлын үр ашигыг нэмэгдүүлэх ашигтай арга юм гэдгийг харуулж байна. 1-р хорооноос бусад хогийн ил задгай гол гол цэгүүд амжилттайгаар устаж алга болсон, эсвэл багассан байна. Хог хаях журам саадгүй хэрэгжихэд хэд хэдэн чухал хүчин зүйл байсан:

### **Хорооны Засаг даргын удирдлага**

Хорооны Засаг даргын хүчтэй удирдлага нь СӨХ-үүдэд нөлөөлж байсан. СӨХ-үүд нь оршин суугчидтай холбогдох гүүр болж ажилладаг учир СӨХ-үүдийн идэвхтэй оролцоо нь саадгүй хэрэгжихэд чухал байсан. Орон сууцны оршин суугчдын дунд олон нийтийн ажиллагаа сул байдаг болон хог ачих үйлчилгээний давтамжыг багасгасан нь эрх чөлөөг нь хязгаарлаж байгаа зэргээс хорооны Засаг даргын дэмжлэггүйгээр СӨХ дангаараа оршин суугчдаас хог хаях журмыг дагаж мөрдөхийг шаардахад хүндрэлтэй юм.

Мөн түүнчлэн хорооны Засаг дарга нь хууль бусаар хог хаягч этгээдийг торгох эрх мэдэлтэй ганц хүн юм. 2, 3 болон 4 дүгээр хороон дээр төсөлд хорооны идэвхтэй оролцоо нь саадгүй хэрэгжих нэгэн хүчин зүйл байсан.

### **СӨХ-ийн үүрэг, оролцоо**

СӨХ-ийн үүрэг, оролцоо нь маш чухал гэдэг нь батлагдсан. Удирдах зөвлөлийн гишүүд нь төслийг идэвхтэй дэмжиж байсан СӨХ нь бусад СӨХ-үүдээ бодвол хог хаях журмыг илүү саадгүй эхлүүлж байсан.

Хэдий тийм боловч шинээр баригдсан орон сууцны байрнуудын СӨХ нь хуучин байрны СӨХ-өөс ялгаатай байсан. Орон сууцны байрыг барьсан барилгын компани нь ихэвчлэн СӨХ-ийн менежментийг үргэлжлүүлэх хариуцдаг. Тэдгээрийн оршин суугчид болон СӨХ-ийн хоорондын харилцаа нь бизнесийн чиглэлтэй бөгөөд олон нийтийн ажиллагаа ихэнхдээ сул байна. Тэдгээр шинэ орон сууцны байруудад хог хаях журам нэвтрүүлэхэд өөр арга зам шаардлагатай болох байх.

### **Үйлчлэгч, жижүүрүүдийн дэмжлэг, туслалцаа**

Хог хаях журам хэрэгжүүлж эхэлсний дараа тэд гол үүрэг гүйцэтгэх учир судалгааны багийнхан хог хаях журмын талаар үйлчлэгч, жижүүрүүдтэй хэлэлцэхэд хангалтай цаг зарцуулсан. Энэ нь тэдний идэвхтэй туслалцаа болон журам саадгүй хэрэгжихэд нөлөөлсөн.

### **Хяналт хийхэд тохирох хүн сонгох**

Нэгдүгээр бүс нутагт судалгааны багийнхан үйлчлэгч, жижүүрийг хяналт хийх хүнээр сонгосон. Бага хэмжээтэй, олон нийтийн замаас тусгаарлагдсан орон сууцны байруудад дээрх хүмүүс хянаж болж байсан. Харин хогийн ил задгай цэг нь олон нийтийн эзэмшлийн газарт байрладаг газарт хяналт хийх хүн нь маш чухал. Хорооны байцаагч гэх мэт эрх мэдэл бүхий хүнээр хяналт хийлгэхээр сонгох хэрэгтэй.

#### **а.2 Зөвлөгөө**

Хог хаях журамтай хамт орцноос хог ачих систем нь сайн ажиллаж байгаа бөгөөд бусад газарт аль болох түргэн нэвтрүүлэх хэрэгтэй.

Хог ачиж цуглуулах шинэ системийг илүү саадгүй хэрэгжүүлэхийн тулд хэд хэдэн асуудлыг шийдэх шаардлагатай байна.

- Олон нийтийг хэрхэн идэвхжүүлэх вэ?

Орон сууцнуудын оршин суугчдын олон нийтийн ажиллагаа нь хүчтэй биш учир зарим нэг асуудлууд байсаар байна. Хэдий сайн зохион байгуулалттай СӨХ байсан ч зарим нэг оршин суугчид нь буруу цагт, буруу газар буюу орцон дотроо хогоо хаясаар байна. Хэдийгээр зарим оршин суугчид өөрсдийнхөө эзэмшлийн хэсэг дотор буруу үйлдэл хийж байгааг хориглох шаардлагатай байгаа ч тэд олон нийтийн эзэмшлийн газарт хогоо хаяхгүй байгаа болохоор энэ нь хорооны Засаг даргын эрх мэдлээс хол юм. СӨХ болон оршин суугчид өөрсдөө энэ асуудлаа шийдэх шаардлагатай.

СӨХ-ийн авах шаардлагатай нэг арга хэмжээ бол олон нийтийн ажиллагааг ихээр зохиож нийтийг идэвхжүүлэх юм. Хэрэв оршин суугчид бие биенээ илүү сайн мэддэг болбол хувиа хичээсэн зан нь үгүй болно.

- Бүх айл өрхүүдэд мэдээллийг хэрхэн түгээх вэ?

Айл өрхүүдэд шуудан хүлээн авах систем байхгүйн улмаас орон сууцны байр бүрт шуудангийн хайрцаг байдаггүй тул ухуулах материалыг тараахын тулд СӨХ айл бүрээр орж уулзах шаардлагатай болсон. Гэсэн хэдий ч олон айл эзэнгүй байдаг нь ялангуяа зуны улиралд хүндрэл учруулж байна. Бүх айл өрхүүдэд ухуулах материал найдвартай хүргэх арга хэмжээ авах шаардлагатай байна.

- Орон сууцны үнэлгээг хэрхэн тогтоох

Орон сууц хувьчлагдсанаас хойш 10 гаруй жил өнгөрч байна. Ихэнх настай оршин суугчид хувьчлалын утгыг бүрэн ойлгоогүй. Жирийн иргэдийн хувьд тэдний орон сууц нь хамгийн том хувийн өмч нь бөгөөд тэдний хувьд орон сууцныхаа өртөгийг хадгалах нь маш чухал юм.

Саяхнаас олон оршин суугчид орон сууцаа засварлах болсон. Хэдий тийм боловч орон сууцныхаа өртөгийг нэмэгдүүлэхийн тулд орон сууцны ойр орчмын байгал орчны нөхцөл байдал нь мөн маш чухал юм. Хэрэв байрны ойр орчим хог хөглөрч тархаагүй, цэвэрхэн байдлаа хадгалж чадвал орон сууцныхаа өртөгийг нэмэгдүүлж чадна. Хог хаях журмыг дагаж мөрдсөнөөр орон сууцныхаа өртөгийг нэмэгдүүлж чадах болно гэдгээ оршин суугчид ойлгох нь чухал.

- Шинээр баригдаж буй орон сууцуудыг хэрхэн хянах

Зарим газарт шинээр орон сууцууд олноор баригдаж байгаа нь зорилтод байруудад хогны машин хүрч очиход хүндрэл үүсгэж байна. Хотын захиргаа хотын төвд шинэ барилга, байгууламж барих төлөвлөгөөгөө хянах хэрэгтэй.

Хотын төвийн олонх барилгууд хог хадгалах байгууламж байхгүй байна. Шинэ барилга байгууламж барих төлөвлөгөө боловсруулахдаа хог хадгалах болон ачиж цуглуулах төлөвлөгөөг мөн боловсруулах шаардлагатай.

- Хог ачих ажлын жинэхэн үр ашигт хэрхэн хүрэх

Туршилтын төсөл хэрэгжихээс өмнө хогийн ил задгай том цэгүүдийг ачихад ТҮК-ийн ажилчид хугацаа их зарцуулж байсан учир хог ачиж цуглуулах ажлын үр ашиг бага байсан. Одоо хог ачих ажлын хугацаа нилээд багассан боловч 3-р хорооны хойд хэсгийн хогийг ачдаг хогны машин нэг рейс хийсэн хэвээр байна. Олон ресторан, кафе болон бар өдөрт хоёр удаа хог ачих үйлчилгээг авдаг тул хогны машин үдээс хойш хоёр дах удаагын хог ачих үйлчилгээгээ хийх хүртлээ хүлээж байдаг.

ТҮК хог ачих ажлын үр ашигийг дээшлүүлж жинэхэн үр ашигт хүрэхийн тулд хогны машиныг зохицуулж, хог ачих хуваарийг дахин шинэчлэх шаардлагатай.

## **b. Ангиан цуглуулах тогтолцоог нэвтрүүлэх**

### **b.1 Сургамж**

- a) Хог ачиж цуглуулах тогтолцоог сайжруулснаар хогийн ил задгай цэгийг алга болгох нь ангилан цуглуулах тогтолцоог нэвтрүүлэхэд эхний чухал алхам юм.
- b) Үйлчлэгч ангилан ялгасан хогны дундаас зарим хогийг ялгаж авч байгаа учир ангилан ялгасан хогны хэмжээ их биш байна
- c) Дахин ашиглагддаг хаягдал гэж ангилагдсан хаягдалыг RDF-ийн түүхий эд болгоход маш тохиромжтой.

#### **b.2 Зөвлөгөө**

- a) Орцноос хог ачих тогтолцоог нэвтрүүлж эхэлснээс хойш 3 жилийн дараа ангилан цуглуулах тогтолцоог нэвтрүүлэх хэрэгтэй. Ангилан цуглуулах тогтолцоог түргэн нэвтрүүлэх шаардлагатай байсан ч гэсэн орцноос хог ачих тогтолцоог нэвтрүүлснээс хойш нэг жил орчим хүлээх шаардлагатай.
- b) Үйлчлэгч дахин ашиглагддаг хаягдлыг ялган авах нь хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ялгахад ашигтай арга юм.

## **6.8 Хог түүгч нарын зохион байгуулалт**

### **6.8.1 Үндэслэл**

Хөгжиж буй орнуудад хог түүгч нар хогийн цэг дээр хаягдал түүхий эд цуглуулж улмаар өөрийнхөө өдөр тутмын амжиргаагаа хангаж амьдрах нь түгээмэл ажиглагддаг. Хог хаягдлын ил задгай хаях, байнга гал гарах, эвгүй үнэр болон хог замбараагүй тархдаг хогийн төвлөрсөн цэг нь хүрээлэн буй орчинд ноцтой сөрөг үр дагавартай.

Улаанбаатар хот ч дээрх байдалтай ижилхэн байдалтай байгаа буюу тус хотын албан ёсны гурван хогийн төвлөрсөн цэг дээр хог хаягдлыг ил задгай хаях болон хогийн цэг дээр хог түүгч нар ажилдаг болно. Улаанбаатар хотын хог хаягдлын 90 орчим хувийг хүлээн авдаг томоохон хогийн төвлөрсөн цэг болох Улаанчулуутын хогийн цэг дээр 300 орчим хог түүгч нар ажиллаж байна.

Энэхүү судалгааны ажил 2004 оны 12 дугаар сард эхэлсэн. Судалгааны хүрээнд боловсруулж буй Мастер төлөвлөгөөнд шинэ хогийн төвлөрсөн цэгийг Нарангийн энгэрт нээж одоогоор ашиглалтын хугацаа нь дуусч нөөц газаргүй болж буй одоогийн УЧХЦ-ийг хаахаар төлөвлөж байна.

Төлөвлөгөөний хэрэгжилтийг шалгах зорилгоор хэд хэдэн туршилтын төслүүдийг хэрэгжүүсэн. Шинээр байгуулах НЭХЦ-т эрүүл ахуйн шаардлага хангасан ландфилын үйл ажиллагаа нэвтрүүлж хог түүгч нарыг хогийн цэг рүү орж ажиллахыг зөвшөөрөхгүй болно. Хог түүгч нарын амжиргааны асуудлыг шийдвэрлэх зорилгоор ландфилын дэргэд ялгах цех байгуулж хог түүгч нарыг ландфил бус тэрхүү цех дотор ажиллахыг дэмжинэ. Ялгах цехийн үлдэгдэл болох хаягдал цаас, хуванцарыг RDF үйлдвэрлэлийн түүхий эд болгон ашиглахаар төлөвлөж байна.

Судалгааны 3 дугаар үе шат 2006 оны 4 дүгээр сард хэрэгжиж эхэлсэн бөгөөд Мастер төлөвлөгөөний бодит хэрэгжилтийг шалгаж үзэх зорилгоор хог хаягдлыг дахин ашиглаж болох ба боломжгүй гэж ангилан цуглуулах туршилтын төслийг Чингэлтэй дүүргийн орон сууцны хороололд хэрэгжүүлэхээр төлөвлөж байна. Туршилтын төслийн хүрээнд цаас, хуванцар гэх мэт дахин ашиглах боломжтой хог хаягдлыг ангилан цуглуулж УЧХЦ дээр байгуулах ялгах цех рүү тээвэрлэж улмаар хог түүгч нар тэндээс хоёрдогч түүхий эдийг цуглуулан үлдэгдэл хаягдлыг RDF түлшний үйлдвэрлэлд түүхий эд болгон ашиглах болно.

Энэхүү туршилтын төсөл болон ирээдүйн эрүүл ахуйн шаардлага хангах ландфилын технологи нэвтрүүлэн хэрэгжүүлэх боломжтой эсэх нь хог түүгч нарын хамтын



ажиллагаанаас ихээхэн шалтгаалах болно. Хог түүгч нарын саналыг авах асуулга судалгаа болон шинэ НЭХЦ байгуулах тухай бага хурлуудыг хэд хэдэн удаа зохион байгуулсан. Хог түүгч нар холбогдох дүрэм журам дагаж мөрдөх болон НЭХЦ-ийг эрүүл ахуйн шаардлага хангасан ландфиллын технологийн дагуу ажиллуулахын тулд хог түүгч нарыг зохион байгуулалтанд оруулах нь зүйтэй гэсэн дүгнэлтэд хүрсэн.

Иймд хог түүгч нарын дунд хамтран ажиллах итгэл төрүүлэх зорилгоор төслийн Монголын талын байгууллага болон Судалгааны баг, юуны түүрүүнд, УЧХЦ дээр хог түүгч нарын зүгээс байгуулж өгөхийг хүсч байсан ялгах цех болон шудрага худалдааны төвийг байгуулахаар шийдсэн. Түүнчлэн, шинэр баригдах ялгах цех болон шудрага худалдааны төвийн үйл ажиллагааг хангахын тулд хог түүгч нарын хамтын ажиллагаа зайлшгүй шаардлагатай болж байна.

Судалгааны 3 дугаар үе шатны хүрээнд хог түүгч нартай долоо хоног бүрийн уулзалтуудыг зохион байгуулсан. 300 орчим хог түүгч нарыг 10 бригад хэсэгт хувааж ахлагч нар болон хог түүгч нарыг төлөөлөх тэргүүлэгчийг тус тус сонгов. Долоо хоногийн уулзалтуудыг бригадын ахлагч, хог түүгч нарын тэргүүлэгч, төслийн Монголын талын байгууллага болон Судалгааны багийн гишүүдийн дунд зохион байгуулав.

Хог түүгч нартай уулзаж ярилцах явцад тэдгээрийн нэлээд хүндрэлтэй асуудал бол нийгэмд эзлэх байр суурь буюу ихэнх хог түүгч нар үндэсний болон бусад өөрийгөө тодорхойлох бичиг баримтгүй байгаа явдал юм. Аливаа бичиг баримтгүй болохоор төр, захиргааны байранд нэвтрэх, аливаа эмнэлгийн үйлчилгээ авах зэрэг боломжгүй байсан.

Иймд дээрх асуудлыг шийдвэрлэх болон хог түүгч нарын хүсэлтийг биелүүлэх зорилгоор тэдгээрт төвлөрсөн цэгийн ажилчин гэсэн статустай, Нөөц компанийн захирлын гарын үсэг болон тамгатай үнэмлэх олгосон. Хог түүгч нарыг зохион байгуулалтанд оруулах, тэдгээрийн нийгэмд эзлэх байр суурийг сайжруулах ажлын явцыг дараах байдлаар тайлбарлав.

### 6.8.2 Хог түүгч нарын долоо хоног бүрийн уулзалтууд

Хог түүгч нарын долоо хоног бүрийн уулзалтуудыг 2006 оны 5 дугаар сарын 3-наас эхлэн 12 дугаар сарын 14-ний өдөр гэхэд нийт 26 уулзалтуудыг зохион байгуулсан бөгөөд тэрхүү уулзалтуудаас 2006 оны 7 дугаар сарын 6-ны өдрийн байдлаар хийсэн 9 уулзалтуудын үер ярилцсан асуудлуудыг дараах байдлаар хураангуйлав..

Огноо	Сэдэв	Тохиролцсон асуудлууд
1-р уулзалт (2006.5.3)	<ul style="list-style-type: none"> <li>УЧХЦ дээрх хэрэгжих ТТ, ялангуяа ялгах цэг болон шудрага худалдааны төвийн тухай танилцуулах.</li> <li>ТТ-ийн хуваарь</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Уулзалтуудыг долоо хоног бүр зохион байгуулах.</li> <li>Уулзалтын өдөр, цагийг тохирох</li> </ul>
2-р уулзалт (2006.5.13)	<ul style="list-style-type: none"> <li>ХТ нарыг бүртгэх</li> <li>Бригад болгон хувааж гишүүдийн тоог тогтоох</li> <li>Бригадын ахлагч нарыг сонгох</li> <li>Тэргүүнийг сонгох</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Бригадын тоо болон бригад бүрийн гишүүдийн тоог дараагийн уулзалтаар шийдвэрлэх.</li> <li>Уулзалтуудыг Пүрэв гаригт хийж байх.</li> </ul>
3-р уулзалт (2006.5.18)	<ul style="list-style-type: none"> <li>Бригадын ахлагч нарыг сонгох</li> <li>Гишүүдийн бүртгэл.</li> <li>Бригадын гишүүн байх нөхцөл, журам</li> <li>Бригадын гишүүдийг ялган тодорхойлох</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>8 бригад болон 173 ХТ нар бүртгэгдсэн.</li> <li>Аливаа бригадын гишүүн болох хүсэлгүй хог түүгч нар ялгах цэг болон шудрага худалдааны төв ашиглахыг хориглох.</li> <li>Гишүүн болох нөхцөл нь 16 наснаас дээш байх ба цэг дээр байнга ажилладаг байх. 15 наснаас доош хүүхдүүдийг ажиллахыг хориглох.</li> <li>Бригадын гишүүдийг тодорхойлох аргыг хэлэлцэж үнэмлэх олгох шийдвэр гаргав. Ярилцлагын явцад олон хог түүгч нар үндэсний үнэмлэхгүй байдаг тул тэдгээрийн хүүхдүүд сургууль явах боломжгүй болдог тухай мэдэгдсэн. Энэхүү асуудлыг шийдвэрлэх тусгай уулзалт зохион байгуулах болов.</li> </ul>

4-р уулзалт (2006.5.25)	<ul style="list-style-type: none"> <li>ХТ нарыг бүртгэх ажлын явц</li> <li>Үнэмлэхний дизайн гаргах</li> <li>Бригад бүрийн гишүүдийн тоо</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>10 бригад, 234 ХТ нар бүртгүүлэв</li> <li>Үнэмлэх дээр фото зураг, код, овог, нэр, төрсөн огноо, хүйс, хүчинтэй байх хугацаа, Нөөц компаний захирлын гарын үсэг болон тамга зэргийг харуулах болов.</li> <li>Нэг бригадын гишүүдийн дээд тал нь 28 ба түүнээс доош гэж тогтов. Шинээр тухайн бригадад хүн нэмэгдэх тохиолдолд тбригадын гишүүдийн зөвшөөрлөөр орно.</li> </ul>
5-р уулзалт (2006.6.8)	<ul style="list-style-type: none"> <li>ХТ нарын бүртгэлийн явц</li> <li>ХТ бүрийн үнэмлэхний фото зураг авах</li> <li>Ялгах цэг болон цэг доторх замын чиглэлийг өөрчилж тавих барилгын ажлын эхлэл</li> <li>Шудрага худалдааны төвийн барилгын схем зураг.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>ХТ бүрийн үнэмлэхний фото зураг авах ажлыг УЧХЦ дээр 2006.6.10-нд 10.00 цагаас авах.</li> <li>Хогийн цэг доторх замыг барих болон хогны машины хөдөлгөөнд аливаа гэр, оромж байгуулан саад болохгүй байх журам тогтоов.</li> <li>Хогийг зөвхөн зааж өгсөн газар хаяж замын баруун талыг цэвэр байлгах.</li> <li>Шудрага худалдааны төвийн агуулахын багууламжийг ченжүүдэд хаягдал түүхий эдийг ХТ нараас өдөр болгон худалдан авч байх гэдэг нөхцөлтэйгээр хариуцана.</li> </ul>
Үнэмлэхний зураг авах эхний ээлж (2006.6.10)	<ul style="list-style-type: none"> <li>Үнэмлэхний фото зураг авав</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>10 бригад, 264 ХТ нар бүртгүүлэв.</li> <li>181ХТ нар фото зураг авхуулахаар ирэв.</li> </ul>
6-р уулзалт (2006.6.15)	<ul style="list-style-type: none"> <li>Фото зураг авах ажлын явц</li> <li>Шудрага худалдааны төвийн байршил</li> <li>Шудрага худалдааны төвийн үйл ажиллганы дүрэм.</li> <li>Цэг дээрх замын арчилгааны дүрэм.</li> <li>Үндэсний үнэмлэхний бүртгэл</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Үнэмлэхний фото зураг авахад бас нэг өдөр ажиллах болно. Тэрхүү өдөр ирээгүй хүмүүсийг бригадын гишүүдийн тооноос хасч үнэмлэх олгохгүй болно. Зураг авхуулаагүй ХТ нарын нэрсийн жагсаалтыг бригадын ахлагч нарт гардуулав.</li> <li>Шудрага худалдааны төвийн байршлыг дулаан гаражийн баруун талд байгуулах болов.</li> <li>Шудрага худалдааны төвийн цэвэрлэгээ, дулаан, арчилгааг хэрхэн хангах талаар ярилцаж дараагийн уулзалтаар шийдвэрлэхээр болов.</li> <li>Хэдэн асуудал ярилцсаны дунд замын хөдөлгөөнд саад учруулахгүй байх, замын баруун талыг цэвэр байлгах, машин дээр гарахыг хориглох зэрэг асуудлуудаар санал солилцож холбогдох шийдвэрүүдийг гаргав.</li> <li>Хотын иргэний бүртгэл, мэдээллийн төвийн захирал, ажилтны хамт ирж үндэсний үнэмлэхгүй хүмүүс хэрхэн үнэмлэхээ авах тухай тайлбар хийв.</li> </ul>
Үнэмлэхний зураг авах 2-р ээлж (2006.6.17)	<ul style="list-style-type: none"> <li>Үнэмлэхний фото зураг авах ажлыг хоёр дахь удаагаа хийв.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>41 ХТ нар фотоо зураг авхуулсан. Нийт 222 фото зураг авав.</li> </ul>



Бригадын ахлагч нартай хийх долоо хоног бүрийн уулзалт



Судалгааын хүрээнд дулаан гараж байгуулж цахилгаан хангамжийг шийдвэрлэж өгсөн тул ХТ нарын уулзалтын үер компьютер болон прожектор ашиглаж байна.



Дулаан гаражид үнэмлэхний фото зураг авч буй байдал.



Үндэсний үнэмлэх хэрхэн авах тухай Нийслэлийн иргэний бүртгэл, мэдээллийн төвийн дэд захирал тайлбар өгч буй байдал.

### 6.8.3 Хог түүгч нарт үнэмлэх олгох

#### а. Үндэслэл

Хог түүгч нарыг хэрхэн бригад болгон хуваах, бүртгэх зэрэг асуудлуудыг хэлэлцэх зорилгоор хог түүгч нар, Нөөц болон Судалгааны баг хооронд хэд хэдэн уулзалтуудыг зохион байгуулсан. Бүртгэгдсэн хог түүгч нар буюу бригадын гишүүдийг бусдаас ялгах зорилгоор дүрэмт хувцас эсвэл хантааз нэвтрүүлэх гэсэн санал гаргасан боловч эцсийн шатанд үнэмлэх олгох нь зүйтэй гэсэн шийдвэрт хүрсэн. Монгол Улсын хуулийн дагуу 16-аас дээш насны хүн үндэсний иргэний үнэмлэх авах шаардлагтай боловч ерөөсөө огт үнэмлэхгүй хог түүгч нар олон болохыг тогтоосон. Үнэмлэхгүй байгаа гол шалтгаанууд, үүнд:


- Хөдөө орон нутгаас олон хүмүүс ирдэг бөгөөд тэдгээр нь төрсний гэрчилгээ гэх мэт бичиг баримтгүй байх.
- Тухайн хүн ажилд ороход ажил олгогч нь иргэний үнэмлэхийг хураан авдаг бөгөөд эргүүлж өгөөгүй байх.
- Мөнгө олох зорилгоор иргэний үнэмлэхээ худалдах.

Үнэмлэхний фото зураг авах явцад хийсэн хээрийн судалгааны хүрээнд хог түүгч нарын 60 орчим хувь нь үндэсний иргэний үнэмлэхгүй байгаа нь тогтоогдож улмаар тэдгээр хүмүүс нийгэм, эмнэлгийн суурь үйлчилгээ авах боломжгүйн сацуу хүүхдүүдийг нь сургуульд авдаггүй байна.

Үнэмлэхийг хог түүгч нарт төвлөрсөн цэгийн ажилчин гэж тодорхойлж Нөөц компанийн гарын үсэг болон тамга дарах санал гаргахад нийт хог түүгч нар хүлээн зөвшөөрсөн болно.

#### б. Үнэмлэхний загвар

Үнэмлэхний загварыг хог түүгч нарын 4 дүгээр уулзалтаар ярилцаж дараах асуудлуудыг үнэмлэх дээр оруулах нь зүйтэй гэж үзэв.



### с. Үнэмлэхний фото зураг авалт

Фото зураг авах эхний ээлжийг 2006 оны 6 дугаар сарын 10, хоёрдугаар ээлжийг 17-ны өдөр тус тус зохион байгуулан авсан. Амралтын өдөр таарсан боловч эхний өдөр 180 орчим, хоёрдугаар өдөр 40 орчим хог түүгч нар ирж зургаа авхуулсан. Үнэмлэхтэй болно гэдэг хог түүгч нарт нэлээд ач холбогдолтой асуудал байсан бөгөөд бид нарыг зураг авах гээд хогийн цэг дээр ирэхэд хүмүүс зургаа авхуулах гэж дугаарлан зогсож байв. Нийт хог түүгч нар тухайн арга хэмжээнд нэлээд идэвхтэй, сайн дураар оролцсон болохыг тэмэглэх нь зүйтэй.



Фото зураг авахын өмнө тухайн хүнийг бүртгэлтэй тулган хянаж байгаа байдал.



Бүртгүүлэхийн тулд дугаарлаж буй байдал



Фото зураг авахын өмнө хүүхдийнхээ нүүрийг арчиж буй байдал



ЖАЙКА-ийн хөгжлийн судалгааны хүрээнд байгуулсан дулаан гаражид зураг авч буй байдал.



Зарим хүмүүс хол газраас мориор ирж байв



Компьютер дээр бүртгэлтэй тулгаж буй байдал

#### d. Үнэмлэх олгох

Үнэмлэх хүчинтэй байх хугацаа 2007 оны 12 дугаар сарын 31 хүртэл хүчинтэй байхаар хийж дараагаар нь жил болгон сунгах болно. Үнэмлэхний материал хуванцар пластик бөгөөд хэмжээ нь түрийвчний хэмжээтэй байхаар загварыг нь гаргаж үнэмлэхний Глобал Дизайн компанитай хэлэлцээ хийсний дүнд нэг ширхэг үнэмлэх 2,500 төгрөгийн өртөгтэй болов.



Үнэмлэхний нүүр



Үнэмлэхний ар

#### e. Хог түүгч нарын сан

Хог түүгч нарын санг хог түүгчид бие биедээ аливаа гачигдал болон бусад олон нийтийн ажилд зарцуулах зорилгоор өөрсдөө байгуулсан. 10 бригадын ахлагч нар өөрсдийн бригадын гишүүд бүрээс сангийн мөнгийг хураадаг.

Бүх бригадын ахлагч нар сангийн хөрөнгийг Нөөц компанид хадгалуулж хариуцуулан хяналтад байлгах талаар санал нэг байв. Нөөц компанийн удирдлага сангийн зарцуулалтын журмын төслийг гаргаж одоогоор түүний агуулгыг хог түүгч нар ярилцаж байна. Сангийн төслийг 2.8 дугаар бүлэгт хавсаргав.

Сан байгуулах үйл ажиллагаа нь хог түүгч нар албан ёсоор зохион байгуулалтын бүтэц байгуулах анхны алхам бөгөөд тэрхүү санаачлагыг гуравдагч этгээд эсвэл Нөөц компанийн зүгээс шахааж шаардаагүй, өөрсдийн санаачлагаар анх санал тавьж байгуулсан.

#### f. Гал унтраах журам

Хогийн цэг дээр гал гарах нь хүрээлэн буй орчинд хохирол учруулахаас гадна хог түүгч нарт хаягдал түүхий эд цуглуулж өөрсдийн орлогоо хийхэд хүндрэл учруулдаг. Тэрхүү асуудлыг шийдвэрлэхийн тулд хог түүгч нар, Нөөц компани болон ЖАЙКА-ийн судалгааны багийн хооронд нэлээд эрчимтэй ярилцсаны дүнд бригад бүр ээлжээр галын баг байгуулж ажиллахаар болов. Бригад болгон сард гурван өдрийн турш гал унтраах багийн үүргийг Нөөц компанийн хамт гүйцэтгэхээр болов. Гал унтраах бригад нь гал унтраахаас гадна хогийн цэг дээрх галын тухай Нөөц компанид мэдэгдэх болно.

Гал унтрах бригад нь тусгай хантааз өмсөж бусад хог түүгч болон Нөөц компанийн ажилчдаас ялгарах болов..

Хог түүгч нарын гал унтраах хуваарийг мэдээллийн зорилгоор хавсаргав.

#### g. Цэвэрлэгээний үйл ажиллагаа

Цэвэрлэгээний ажлыг Нөөц компани болон хог түүгч нарын өөрсдийн санаачилгаар хийв. Хог түүгч нар сайн дурын үндсэн дээр өөрсдийн ажлын байрыг цэвэрлэж байв. Тэрхүү явдал нь хог түүгч нарын мэдлэг ухамсар өөрчлөгдөж улмаар өөрсдийн ажлын байрны нөхцлийг сайжруулахын тулд зохион байгуулалтад орох нь зайлшгүй болсон гэдгийг илэрхийлж байна. Хог түүгч нар хувиа бодож хамтран ажилдаггүй байсан тэрхүү байдлаас эсрэг, өөр зан чанар илэрсэн нь санаанд оромгүй үйл явдал болсон юм



### 6.8.4 Ололтууд

- Эрүүл ахуйн шаардлага хангасан ландфилын технолги нэвтрүүлэх, ялангуяа ирээдүйн хогийн цэг дээр буусан хог хаягдлыг хөрсөөр дарж булаах ажлыг хэрэгжүүлэхийн тулд ажлын талбай дээр хог түүгч нар ажиллахгүй байх нь нэн чухал юм. Иймд хог түүгч нарыг бага багаар зохион байгуулалтанд оруулж улмаар ялгах цех/цэг болон хог хаягдлыг дахин боловсруулах байгууламж дээр ажлын байрыг шилжүүлэх нь зүйтэй. Эрүүл ахуйн шаардлага хангах ландфил нэвтрүүлэх анхны алхам бол хог түүгч нарыг зохион байгуулалтанд оруулах явдал бөгөөд одоогоор УЧХЦ дээр ажиллаж буй хог түүгч нарын дунд тэрхүү зохион байгуулалтыг хэрэгжүүлэх боломжтойг нотолж байна.
- Бусад хөгжиж буй орнуудын хог түүгч нартай харьцуулахад УЧХЦ-ийн хог түүгч нарын мэдлэг ухамсар өндөр, ялангуяа бичиг үсэг мэдэх тул бид нарын боловсруулсан заавар, хүснэгт, тайлан илтгэлүүдийг чөлөөтэй ойлгож хоорондын нэгдсэн ойлголтод хүрэхэд тус дөхөмтэй байв.
- УЧХЦ дээр өмнө нь хог түүгчийн ажил хийж байгаад Нөөц компанийн ажилтан болж цэгийн зохицуулагчийн үүргийг маш сайн гүйцэтгэж байгааг энд тэмдэглэх байна. Тэрээр удирдах ур чадвартай бөгөөд хог түүгч нар түүнд

итгэдэг байна. Хог түүгч нарыг зохион байгуулах нь удирдах чадвартай болон хог түүгч нарын итгэлийг даах хүн байх нь нэн чухал юм.

- Хог түүгч нарын уулзалтыг цаашид үргэлжлүүлэн хэрэгжүүлэх нь хог түүгч нар болон хогийн цэг хариуцах байгууллага болох Нөөц компанийн хоорондын харилцаа холбоог тогтоох, бие биенээ ойлгоход нэн чухал арга хэмжээ болно. Тэрхүү харилцааг НЭХЦ ашиглалтад ортол хадгалах нь чухал юм.

### **6.8.5 Хавсралт**

#### **а. Хог түүгч нарын сан**

Хог түүгч нарын сан болон шаардлагатай үед санг хэрхэн ашиглах тухай уулзалтын тэмдэглэлийн маягтыг дараах байдлаар үзүүлэв.

Батлав: “Нөөц” НӨҮГ-н захирал..... Ж. Жамбалдорж  
*/гарын үсэг ба тамга/*

**СХД-ИЙН 4-Р ХОРООНЫ НУТАГ УЛААНЧУЛУУТЫН  
ТӨВЛӨРСӨН ХОГИЙН ЦЭГ ДЭЭР ХОЁРДОГЧ ТҮҮХИЙ ЭД  
ЯЛГАН АЖИЛЛАГЧ БРИГАДУУДЫН ХУРИМТЛАЛЫН  
САНГ ЗАРЦУУЛАХ ЖУРАМ**

2006-07-07

**1. Зорилго**

Цэг дээр ажиллагч бригадуудын санаачлагаар байгуулах хуримтлалын сангийн зориулалт нь бригадын гишүүдээс хэн нэгэнд гачигдал тохиолдох, эмчилгээ сувилгаанд явах, нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулах, иргэний бичиг баримттай болох, аж амьдрал нь туйлын хүнд болсон үед нь нэг удаагийн буцалтгүй тусламж үзүүдэхэд чиглэгдэнэ.

**2. Санг бүрдүүлэх тухай**

- Бригадын дарга нар гишүүн тус бүрээс долоо хоногт 600 төгрөгийг өөрсдөө бүртгэл хөтлөн хураана.
- Бригадын гишүүдээс орлогын чадваргүй иргэн байвал түүнийг биеийн хөдөлмөрийн ажил гүйцэтгүүлж хөдөлмөрийн нь хөлсийг орлогод тооцож болно.
- Бригадын дарга нарын хураасан мөнгийг “Нөөц” НӨҮГ-ын аж ахуйн нярав цэг дээр очиж санхүүгийн тэмдэг бүхий орлогын ордер бичиж кассын орлогод авна.
- Бүрдүүлсэн хуримтлалын санд “Нөөц” компани тусгайлан журнал хөтөлж байна.

**3. Сангийн зарцуулалтын тухай**

- Сангийн хөрөнгөөс зарцуулахдаа бригадууд тус бүрийдээ хуралаа хийсэн байна.
- Бригадын гаргасан шийдвэрийг тухайн бригадын дарга бусад бригадын дарга нарт танилцуулснаар хамтын бөгөөд эцсийн шийдвэр болно.
- Сангийн орлого, зарцуулалтын байдлыг “Нөөц” НӨҮГ-ын санхүүгээс бригадын дарга нарт долоо хоног тутам танилцуудна.
- Хурлын тэмдэглэл хөтлөх 2 төрлийн маягтыг “Нөөц” НӨҮГ-ээс гаргана.
- Бригадууд санд орлого хэрхэн төвлөрүүлсэнийг харгалзан сангаас авах тусламжийн хэмжээг шийдвэрлэх эрх бригадуудад хадгалагдана.
- Ихээхэн хэмжээний гал гарсан үед ээлжийн биш бригадуудаас нэмэгдэл хүч авбал тэдгээр ажиллагсдад сангаас урамшуулал олгоно.

“НӨӨЦ” НӨҮГ



Улаанчулуутын төвлөрсөн хогийн цэгт хоёрдогч түүхий эд  
ангилан ялгагч бригадын хурлын тэмдэглэл  
№

Хурлыг 2006 оны . . . р сарын . . . өдөр бригадын гишүүдээс. . . нь оролцон, бригадын дарга.....удирдан явуулсан.

Хурлаар.....

.....

.....

..... асуудлыг хэлэлцсэн.

Бригадын гишүүдийн асуулт, хариулт.....

.....

.....

.....

.....

Бригадын гишүүдийн санал.....

.....

.....

.....

.....

Шийдвэрлэсэн байдал.....

.....

.....

.....

.....

Тэмдэглэл хөтөлсөн

Бригадын дарга...../ /

Улаанчулуутын төвлөрсөн хогийн цэгт хоёрдогч түүхий эд  
ангилаан ялгагч бригадын дарга нарын хурлын тэмдэглэл  
№

Хурлыг 2006 оны . . . р сарын . . . өдөр бригадын . . даргаас ... нь оролцон, бригадын  
дарга нарын ахлагч .....удирдан явуулсан.

Хурлаар.....

.....

.....

..... асуудлыг хэлэлцсэн.

Бригадын дарга нарын асуулт, хариулт.....

.....

.....

.....

.....

Бригадын дарга нарын санал.....

.....

.....

.....

.....

Шийдвэрлэсэн байдал.....

.....

.....

.....

.....

Тэмдэглэл хөтөлсөн

Бригадын дарга нарын ахлагч ...../

Байлцсан “Нөөц” НӨҮГ-ын талбайн зохицуулагч ..... /Ч.Баттунгалаг/

